



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/439

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2024 оны 20 дугаар хурлын шийдвэрийг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зудын улмаас хорогдсон малын тоог нягтлан тогтоох, сэг зэмийн устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээнд хяналт тавих, малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд сумдад хүргэх өвс тэжээлийн тээврийн зардал 9.028.800 (Есөн сая хорин найман мянга найман зуу) төгрөгийг улсын Онцгой комиссоос хуваарилагдсан хөрөнгийн эх үүсвэрээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

